



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/157

Номгон

Г Хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэг
байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.2, 17.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”, хамгаалах байр болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Наранбаяр-(Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Д.Сарангарав - (Хууль эрх, зүйн хэлтсийн дарга)

Б.Оюутболд - (Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа)

Н.Энхжаргал- (Эрүүл мэндийн газрын дарга)

Ц.Энхтөр- (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)


Д.Амарсанаа- (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Нарийн бичгийн дарга Н.Мэндбаяр- (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

2. Дээрх төвүүдийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын танилцуулгыг нэгдүгээр улиралд багтаан танилцуулахыг ажлын хэсэг (Б.Наранбаяр)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхсоёл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220373